

## ‘УЛААН’ НЭР ОРОЛЦСОН ГАЗАРЗҮЙН БИЕТИЙН НЭРИЙГ МОНГОЛ-ЯПОН ХЭЛНЭЭ ДҮЙЛГЭН ҮЗЭХ НЬ

П.Энхжаргал

Монгол газар нутгийн нэр (МГНН)-ийн цогцод өнгө заасан нэрийн бүрэлдүүний давтамж өндөр болох нь судалгааны олон сурвалжаас тодорхой харагддаг. Түүнийг нүүдэлчдийн газар нутгаа нэрлэх нэгэн онцлог хэмээн үзэх нь бий. Энэхүү илтгэлд бид монгол, япон хэлнээ газарзүйн биетийг *улаан* өнгөөр тодотгон нэрлэсэн байдлыг дүйлгэн үзсэн болно.

Газар нутгийн нэрийн бүрэлдэхүүнд орсон өнгө заасан нэрийн талаар судлаачид цухас боловч авч үзсэн байна. Тухайлбал, Таникава Кэн-ичи хөх өнгө заасан нэр бүхий газар нутгийн нэрийн илэрхийлэх утгыг угсаатны зүйн үүднээс авч үзэн, эдгээр нэр нь ихэвчлэн оршуулгын газартай холбоотой байдаг [14:32-42] болохыг тогтоожээ. Үэно Томоко далайн эрэг хавийн газар нутгийн нэрд улаан, хар, хөх, цагаан зэрэг өнгө заасан нэр ордог [11:153] болохыг дурьджээ. Э.Равдан “Монгол орны газар нутгийн мянган нэр тутамд ойролцоогоор 20 орчим хувьд нь “цагаан”, “бор”, “хар” гэх мэт хүртээл нэр ордог” [8:200] болохыг тэмдэглэсэн байна. О.Т.Молчанова Уулын алгайн газар нутгийн нэрийн 14 хувийг хар, цагаан, улаан, шар, хөх зэрэг өнгө заасан нэр эзэлдэг болохыг, мөн улаан өнгө нь 2 гишүүнт бүтцэд идэвхитэй оролцож, ихэнх тохиолдолд уулын тухайт нэрийг тодотгон ордог болохыг [4:25-26] тогтоосон байна.

Бид эл судалгаанд Монгол Газар Нутгийн Нэрийн цахим хөмрөг (Э.Равдан “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь”, 1970-1980 он, 8 дэвтэр, CD-тэй, УБ., 2004, 214805 нэр бүхий ) болон Япон Газар Нутгийн Нэрийн цахим хөмрөг (1978-1990 хооронд Кадокава хэвлэлийн газраас эрхлэн гаргасан нийт 46 боть 500,000 гаруй толгой үгтэй “Кадокава Японы газрын нэрийн их толь бичиг”-ийн нэрийн хэлхээ болох 47-р ботиос зөвхөн газар нутгийн нэрийг (自然地名) түүвэрлэн авч үүсгэсэн 26123 газар нутгийн нэр бүхий цахим хөмрөг бөгөөд уг сангаасаа хялбархан хайлт хийх боломж бүхий хайлтын хэрэгсэлтэй.)-ийг ашигласан бөгөөд уг 2 хөмрөгөөс түүвэрлэсэн “улаан” өнгө заасан нэр бүхий 8753 монгол газар нутгийн нэр, 211 япон газар нутгийн нэрд тулгуурласан болно. “Улаан” орсон газарзүйн биетийн нэр нь монгол хэлнээ нийт нэрийн 4 хувь, харин япон хэлнээ нийт нэрийн 0,8 хувийг эзэлж байна.

Юуны өмнө судалгааны эх хэрэглэхүүн болох “улаан” нэр орсон газарзүйн биетийн нэрийг бүтцийн хувьд задлан үзэхэд 3 гишүүнт бүтцээр илэрсэн нэр хоёр хэлнээ давтамж өндөртэй байгаа нь ажиглагдав. Монгол хэлнээ *Булагт Улаан Өндөр Овоот толгой* (Дундговь), *Улаан Чулуутын Урд Эх ам* (Хөвсгөл), *Элст Сайрын Ар Улаан толгой* (Говь-Алтай), *Цогт Бригадын Хуучин Төв Улаан хөндий (Завхан)* гэх зэрэг 5-6 гишүүнт бүтэц байдаг бол япон хэлнээ ийм бүтэц илэрсэнгүй. (Хүснэгт №1)

**П.Энхжаргал**

Монгол улсын их сургууль  
kouma79@yahoo.com

**С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра**

*Монголын газрын зураг, газрын нэр судлал*

*“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6*

Хүснэгт №1 “Улаан нэр орсон газар нутгийн нэрийн бүтэц”

Бүрэлдэхүүн	Улаан	
	Монгол	Япон
2 гишүүнт бүтцээр илэрсэн нэр	1587	30
3 гишүүнт бүтцээр илэрсэн нэр	6405	160
4 гишүүнт бүтцээр илэрсэн нэр	724	21
5 гишүүнт бүтцээр илэрсэн нэр	35	
6 гишүүнт бүтцээр илэрсэн нэр	2	
Нийт	<b>8753</b>	<b>211</b>

Газар нутгийн нэрийг хэв шинжээр нь задлан үзснээр *улаан* нэр чухам ямар газарзүйн биетийг тодотгон ордог, өөрөөр хэлбэл монгол, япон ард түмэн ямар зүйлийг уг өнгөөр тодотгон нэрлэдэг вэ гэдгийг тогтооход дөхөмтэй болно. Учир нь 2 гишүүнт бүтцийн хувьд *Улаан ам* (50 удаа), *Акапита-Улаан намаг* (5 удаа) зэргээр ямар биетийг тодотгож буй нь тодорхой бол *Улааны сайр* (4 удаа) гэхэд Улаан (Гол)-ын сайр уу, Улаан (Уулын) сайр уу, улаан чухам юуг тодотгож буй нь тодорхойгүй болно. Мөн 3 гишүүнт бүтцийн хувьд “улаан” нэр *Эхний Улаан хад*, *Нүдтэй Улаан уул*, *Шуурдаг Улаан толгой*, *Дунд Улаан уул*, *Салхитын Улаан нуур*, *Янгирт Улаан хяр* зэргээр хоёрдугаар гишүүн болсон тохиолдолд, *Улаан Эрэгт сайр*, *Улаан Эрэгийн хяр*, *Улаан Цохиотын толгод* гэх зэргээр хоёрдугаар гишүүн нь оноосон нэрийн үүргээр орсон дэвсгэр нэр бол харьцангуй тодорхой болно. Харин *Улаан Баян уул*, *Аказураута-Улаан нүүр уул*, *Улаан Дэл худаг Akatanigawa-Улаан жалга гол* зэрэг хэвшинжийн хувьд хоёрдугаар гишүүн ерийн нэр үү оноосон нэрийн үүргээр орсон гэдгээс шалтгаалан улаан нэр ямар биетийг тогтоох шаардлагатай болно.

Монгол газар нутгийн нэрийн цахим хөмрөгийн хайлтаар илэрсэн 8753 *улаан* орсон нэрийг хэв шинжийн хувьд тодорхойлоход “улаан”, “улааны” гэсэн хоёр хэлбэртэй байна. “Улааны” буюу арын дэвсгэр нэр хэмнэгдэж, дэвсгэр үүргээр орсон, нэрээс тодотгож буй биетийг шууд тогтоох боломжгүй 383 нэрийг судалгаанд оруулаагүй болно. Япон хэлний хувьд хэлзүйн ийм үзэгдэл илэрдэггүй боловч газарзүйн биетийн нэрийг тэмдэглэж буй ханз нь ханзны үндсэн утгаар бус харин тухайн нэрийн дуудлагыг галигласан байх нь тохиолддог. Бид хайлтаар илэрсэн 221 нэрээс хэдийгээр “улаан” өнгө заах 赤 (ака) ханзаар тэмдэглэгдсэн боловч 關伽 (ака) бурханд усаар дээж тавих савыг заасан утга бүхий, тухайлбал, 赤井山 (акай уата)-улаан уул→關伽井山 (акай уата) Сав уул гэх зэрэг “улаан”-аас өөр утга бүхий 10 нэрийг хассан болно.

Улаанаар монгол хэлнээ 138, япон хэлнээ 47 төрлийн газарзүйн биетийг тодотгон нэрлэсэн байна. (график №1)

### Улаан




График №1 “Улаанаар тодотгон нэрлэсэн байдал”

Монгол хэлнээ уултай холбоотой 80 биетийг, устай холбоотой 24 зүйлийг, газрын тэгш, хотгор гадаргуутай холбоотой 16 зүйлийг, ургамалтай холбогдох 18 зүйлийг, япон хэлнээ уултай холбоотой 9, устай холбоотой 22, гадаргуугийн тэгш хотгортой холбоотой 13, ургамалтай холбоотой 2 зүйлийг тус тус *улаанаар* тодотгон нэрлэсэн байна.

Улаанаар тодотгон нэрлэсэн уулын тухайт зүйл нь монгол хэлнээ *толгой, уул, хад, чулуу дэл, овоо, үзүүр, даваа, хошуу, ам, толгод, цохио, хөтөл, цав, энгэр, богоч, хамар, хуруу, ухаа, хясаа, тээг, хүрээ, хяр гозгор, асга, чих, дав, байц, нуруу, боом, хавцал, хайрхан, завсар, нүүр, салаа, дөрөлж, сархиа, хөв, бураа, гүвээ, хургад, царам, дух, зоо орой, эрэгцэг, сэрвэн, хавчиг, явар, адарга, дэвсэг, хонх, ширээ, гануу, дэнж, шанаа, аараг, манхан, сээр, хэц, бэл, гүдэн, товог, хавчуу, хүүш, хянга, анталаг, ар, онь, таг, хуудас, цүнхэг, зураа, сарьдаг, сүүж, тавцан, уулс, хүйс, цонж, шил* зэрэг, япон хэлнээ *толгод, өндөрлөг, даваа, уул, нуруу, хад, оргил, даваа, чулуу* зэрэг биет байна.

Усны тухайт зүйлийн хувьд монгол хэлнээ *худаг, эрэг, нуур, тойром, булаг, сайр, шанд, бэлчир, хужир, ус, гол, шавар, усан сан, булан, даац, горхи, далан, бүрд, хөвөө, гарам, далай, мараа, харз, хүрхэрээ* зэрэг нэр байна. Япон хэлнээ устай холбоотой *арал, хошуу, гол, булан, цөөрөм, жалгын гол, эрэг, намаг, булаг, булан, далайн эрэг, халуун рашаан, халуун ус, тогтоол цөөрөм, хүрхэрээ, тохой, булан, эргийн хясаа, рашаан, хамар* зэрэг байна.

Газрын тэгш, хотгор гадаргуутай холбоотой биет нь монгол хэлнээ *жалга, дов, зуух, хонхор, хоолой, говь, хөндий, шал, тал, хунх, хүнх, элс, ховдол, цайдам, судаг, нуга* зэрэг нэр япон хэлнээ *тал, хөндий, ангал, нүх, хөндий, хотгор, нүд, уулзвар, хөндий, жалга, хиргисүүр, уурхай* гэх мэт байна.

Ургамлаас монгол хэлнээ *мод, бургас, хус, харгана, шивээ, бут, тайга, шаваг, ширэнгэ, бударгана, хаг, хожуул, сухай, хайлаас, зүлэг, цагдуул, шарилж, шугуйг* япон хэлнээ *үнэрт мод, ойг* улаанаар тодотгосон байна.

Дээрхээс авч үзвэл уулын тухайт биетийн хувьд монгол хэлнээ “улаан толгой”, япон хэлнээ “улаан уул”, усны тухайт биетийн хувьд худгийг хүний гараар бүтсэн зүйл хэмээн үзвэл монгол хэлнээ “улаан эрэг”, япон хэлнээ “улаан гол”, газрын тэгш, хотгор гадаргуутай холбоотой биетийн хувьд монгол хэлнээ “улаан жалга”, япон хэлнээ “улаан хөндий” хамгийн өндөр давтамжтай бол ургамлын аймагтай холбоотой биетийг “улаан” өнгөөр тодотгон нэрлэх нь монгол хэлнээ түгээмэл байна.

“Улаан” нэрээр тодотгосон газарзүйн биетийн нэрийг хоёр хэлнээ харьцуулан авч үзвэл монголчууд уулын тухайт биетийг ихэвчлэн өнгөөр нэрлэдэг бол япончууд усны тухайт биетийг улаан өнгөөр нэрлэх нь их байна.

Газар нутгийн нэрд хэрэглэгдэх улаан нэрийн утгалбарыг тогтоохын тулд түүний үгийн сангийн утгыг толь бичгээс тодруулах шаардлагатай. Монгол хэлний тайлбар тольд “улаан” үгийн утгыг “1. Гал ба цус мэтийн өнгө; 2. Хувьсгалын утга чанар бүхий; 3. Биеэр, халхлах, жийрэглэх юмгүй; 4. юмыг хэтрүүлэн хийгч, цагаандаа гарсан, балмад; 5. нялх балчир; 6. шунахай ховдог” [6:2874-2877] гэж тодорхойлсон байна. Ц.Норжин “Улаан (ulagan) тэм. 1. гал ба цус мэтийн өнгө; 2. цагаан адууны улаан шалзтай зүсэм 3. бусад адгуусны зээрдтэй адил зүсэм: улаан үхэр, улаан тэмээ, улаан алаг хонь 4. тэнгэрийн эрхэсийн арван өнгийн гуравдугаар: улаан барс жил 5. нүдний салст бүрхэвч улайн өвдөх үрэвсэл: нүдний улаан тусах 6. шагайн тэмээн тал 7. шил. дээд хэмжээний улс төрийн ухамсар ба хувьсгалч чанарын бэлгэ тэмдэг 8. шил. ховдог шунахай.” [7:487] гэсэн утгыг илэрхийлнэ гэж үзсэн байна.

Эдгээр утгаас үзэхэд газар нутгийн нэрд улаан өнгө заасан утга, мөн хоосон буюу өвс ургамалгүй гэсэн утга, шороо ихээр холилдсон тогтмол ус гэсэн утгалбарууд хэрэглэгдэх боломжтой гэж үзэж байна.

Япон хэлний улаан өнгө заасан нэр *aka*-г япон хэлний тайлбар тольд “(нэгэн тайлбарт хар өнгийн эсрэгцэл бөгөөд үндсэн утга нь гэгээ орох, цайрах) 1. Долоон өнгийн нэг, цус шиг өнгө. Мөн *hi* (緋) ув улаан, *kurenai* (紅) час улаан, *suu* (朱) шунх, *cha* (茶) бор өнгө зэргийн ерөнхий нэр. 2. Улаан өнгөтэй холбоотой зүйлс: улаан зэс 3. бүрэн, ор хоосон

зэрэг утга илэрхийлэх үг; улаан нүцгэн, улаан шившиг” [13:28] гэж тайлбарласан байна. К.Такэи “Улаан нэрээр нэрлэгдэх өнгийн хүрээ туйлын өргөн бөгөөд хөхөлбөр улаанаас улаан шар, бор хүрнийг хүртэл улаан гэж нэрлэх нь бий” [15:31] гэж улаан төрлийн өнгийн айн гол төлөөлөл болох үүднээс нь үзжээ.

Монгол хэлнээ улаан өнгө бэлгэдлийн нэгэн чухал бүрдүүлбэр болдог. С.Дулам улаан өнгийн бэлгэдлийн үүсэл гарлыг “байгаль, ертөнц, хүний соёл иргэншил дээрх хамгийн чухал үзэгдэл болсон гал дөлийг төлөөлдөг. Энэ нь хүний бие дээр авч хэлэхлээр эрүүл биеийн цусны өнгө шунх улаантай (ул) авцалдан үлгэр, туульсын баатдын идэр чийрэг, цог золбоот дүр төрхийг бүтээдэг” [2:41] хэмээн үзсэн байна. Түүнчлэн галын өнгөөс үүдэн гал түлэх түлээ, чанах цай, түлээ зөөсөн хангайгаа ч тодотгон нэрлэдэг гээд “«шугуйн хүрэн уулын өмнө элгэн талд ургадаг хар л улаан харгайг сугалж татаад бат л улаан галыг дүрэлзтэл түлээд явна» гэхчлэн өгүүлсэн нь байгалийн юм үзэгдлийн эх өнгө байгаа билээ” [2:45] гэж байгаль, түүний үзэгдэлтэй холбон тайлбарласан байна. Түүнчлэн “улаан өнгө баяр баясгалангийн өнгө” [10:62] бөгөөд орчин цагт “цог золбоо, бэрхшээлийг ялан дийлэх мохошгүй зориг хүч, өөдрөг хийморьтой [3:126] байхыг бэлгэдэх болжээ.

Япончууд “Улаан бол галын өнгө бөгөөд шатаж буй галын дүрэлзсэн дөл гэдгээс эрч хүч, баяр хөөр, үнэнч сэтгэл, хувьсгал, сэтгэл хөөрөл зэргийг бэлгэддэг” [15:32] гэж үздэг. Мөн “улаан өнгө амь насны өнгө бөгөөд бурхны өнгө цагаантай хосолбол бурхны хүчээр тэтгэгдсэн эцэс төгсгөлгүй амьдрал, аз жаргалыг бэлгэддэг” [12:521] хэмээсэн байна. Эртний япончуудын оршуулга, булшны чулуун ханан дээр улаан өнгөөр тойрог дүрсэлж, мөнхийн амьдралыг бэлгэдсэн байдаг. Орчин үед цагаан, улааны хослолыг баяр ёслол болон хүндэтгэлд хэрэглэдэг. Түүнчлэн шинто шашны сүмийн гадна хамгаалалт хаалгыг улаанаар буддаг нь гал, нарны өнгөөр сахин хамгаалах утгатай байна.

Дээрхээс нэгтгэн үзэхэд монгол, япон хэлнээ “улаан” өнгө нь *галын өнгө, улаан хоосон, нүцгэн* гэсэн утгаар ижил, галын өнгө гэдэг нийтлэг төсөөллөөс үүдэн *цог золбоо, эрүүл, хүчтэй* гэсэн бэлгэдэл утга мөн адил байна. Харин монгол хэлнээ хар-цагаан, япон хэлнээ хар-улаан нь өдөр-шөнийн эсрэгцэл болдог ажээ.

Газар нутгийн нэрд орсон улаан өнгийн утгыг О.Т.Молчанова “Уулын Алтайн газар нутгийн нэрд орох кызыл нь “улаан”, “хурц улбар шар”, “улаан буурал”, “тоосгон улаан”, “хар хүрэн” гэх зэрэг утгатай байдаг. Монгол хэлний *улаан/ulan* мөн адил” [5:1150] гэж үзжээ. Харин Н.И.Гармаева улаан нэр “газар нутгийн нэрд бүтээлч байгаа нь “улаан өнгө” баяр баясал, аз жаргал, ялалт, зочломтгой байдлыг бэлгэддэгтэй холбоотой. Монголчууд гал, нар зэрэг нь хүмүүст гэрэл, дулааныг өгдөг гэж үздэг байсан” [1:85-88] гэж үзсэн хэдий ч түүнийгээ тодорхой жишээ баримтаар дэлгэрэнгүй тайлбарлаагүй байна.

Газрын нэрд орсон *улаан* нь өнгө заахаас өөр утга илэрхийлж байгаа эсэхийг тодруулахын тулд домгоор тайлсан байдлыг авч үзье. “Монгол газар нутгийн мянган нэрийн домгийн чуулган”-д “*Алгуй Улаан цав, Горхийн Улаан уул, Гурван Улаан уул, Гурван Улаан чулуу, Даагай Улаан толгой, Даржаагийн Улаан хад, Сүвэн Баян Улаан уул, Сэтэрхий Улаан хад, Тогоот Улаан хад, Тулын Улаан даваа, Улаан Алаг уул, Улаан Байшинт боом, Улаан булаг, Улаан говь, Улаан даваа, Улаан Давааны боргио, Улаан Дэлийн ухаа, Улаан Модны даваа, Улаан Өндөр уул, Улаан толгой, Улаан Үнээт уул, Улаан Хаалга уул, Улаан Хаалга хад, Улаан хад, Улаан Хайрхан уул, Улаан хадаг, Улаан Хайрхан чулуу, Шивээт Улаан уул, Шовгор Улааны агуй, Уушиг Дуугарахын Улаан уул, Хадат Улаан уул, Хотгорын Улаан Толгойн бууц* зэрэг 30 гаруй нэрийн гарвалыг домгоор тайлсан байна. Домогт эдгээр нэрийн утгыг дараах байдлаар тайлжээ.

- **тухайн газрын улайран харагдах байдлаар нэрлэсэн** Тухайлбал, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын байх Алгуй Улаан цав нь олгой шиг хэлбэртэй улаан хүрэн өнгөтэй өндөр уул, Завхан аймгийн Ургамал сумын Гурван Улаан уул, мөн Ховдын Эрдэнэбүрэнд байдаг Гурван Улаан чулуу зэргийг баруун монголд алдартай Сартагтай баатрын домогтой холбон тайлбарласан агаад сүрлэг уулс гэсэн байна. Түүнчлэн Даржаагийн Улаан хад, Улаан Алаг уул, Улаан Өндөр уул, Улаан Хаалга

уул, Улаан Хайрхан чулуу, Шивээт Улаан уул гэх зэрэг нэрийн хувьд харагдах өнгөөр нэрлэсэн байна.

- **шүтлэгтэй холбогдох** Ховд аймгийн Дөргөн суманд байх Улаан Алаг уул, Алтрагийн голын эхлэх амыг хаасан час улаан чулуу, шороон хөрстэй малын хаа хэлбэртэй уул болох Улаан Хаалга уул, Уушиг Дуугарахын Улаан уул (Онгон Улаан) зэргийг шүтлэгтэй уул хэмээжээ.
- **дайн тулаантай холбоотой** Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт байх Улаан модны давааг Гэгээний хийдийн лам нарыг хоморголон хөнөөсөн, Өөлд, Халхын байлдаанд олон хүн хөнөөгдсөн “Улаан толгой” гэх зэрэг нэрийг цус их урсгасан газар гэж тайлсан байна.
- Зарим нэрийн хувьд өнгөтэй огт холбоогүй байдал ч ажиглагдаж байна. Тухайлбал, “Төв аймгийн Эрдэнэсант сумын нутагт оршин байгаа газрыг одоо *Улаан худаг* гэж нэрлэдэг. Хуучин урд дэрсэнд нь долоон худагтай байжээ. “Долоон худаг” нэр аман болон бичгийн алдаанаас болсон уу, эсвэл долоогийн тооноос цээрлэсэн юм болов уу? Улаан худаг гэж албан ёсоор нэрлэх болсон билээ” [9:523] гэсэн бол Архангай аймгийн Тариат сумын Суман голын гүүрнээс доош том, том хад дамнан оволзсон сүр чимээ ихтэй боргио байх бөгөөд тул загасны тэнхээ шалгадаг тул *Улаан Тулын даваа* буюу *Улаан Давааны боргио* гэсэн нь өнгөтэй, мөн уултай огт хамаагүй нэр байна.

Домгоор тайлсан байдлаас улаан нэр нь өнгө заасан утга, мөн уулын хувьд хад чулуу ихтэй байдал, мөн магадгүй шүтлэгтэй уул байх боломжтой гэж үзэж байна.

Япон газрын нэрийн хувьд Яманака Жоота *улаан* бүхий 6 нэрийн гарвалыг [16:16-17] тайлан бичсэн байна. Үүнд:

赤岩山 (Aka iwa yama - Улаан хад уул) Япон (Хойд) Альпийн уулс гэгдэх 2769 м өндөр уул бөгөөд нэрийн дагуу улаан хадтай уул.

赤牛岳 (Aka ushi dake - Улаан үхэр оргил) хэлбэр нь улаан үхэртэй адил. Япон (Хойд) Альпийн уулс, 2846 м.

赤城山 (Aka gi san - Улаан цайз уул сөнөсөн галт уулын нэр. Ака галын бурхны шилжсэн нэр. Эртний япон хэлээ шинтогийн сүмийн утга, Акаги гэдэг нь галын бурхныг тахидаг газар.

赤湯 (Aka yu - Улаан халуун ус) Ямагата мужийн өмнөд хэсэг байх халуун рашаан ихтэй газар. Давс, шүлтлэг, газрын хөрсний өнгө улаанаас ийн нэрлэсэн гэжээ. Үүнээс үзвэл тухайн газрын харагдах өнгөөр нэрлэсэн байдал ажиглагдаж байна.

Хүн төрөлхтөн аливаа зүйлийг нэрлэхдээ түүний олон онцлог шинжээс зөвхөн нэг шинжийг илүү анхаарлаа төвлөрүүлдэг. Өнгөөр нэрлэх нь ч газарзүйн биетийн хэлбэр, хэмжээ, тоо ширхэг зэрэг олон шинжийн нэгийг л анхааран үзсэн хэрэг болно. Бидний авч үзсэн газарзүйн биетийг тодотгож буй “*улаан*” өнгө бидний байнга хардаг улаан туг, гал, цус шиг биш байх бөгөөд биет бүхэлдээ улаан байх шаардлагагүй болох нь тодорхой билээ.

“Улаан” нэрээр тодотгосон газарзүйн биетийн нэрийг хоёр хэлнээ харьцуулан авч үзвэл монголчууд уулын тухайт биетийг ихэвчлэн өнгөөр нэрлэдэг бол япончууд усны тухайт биетийг улаан өнгөөр нэрлэх нь их байна. Энэ нь ус өөрөө улаан өнгөтэй бус японы байгаль газарзүйн онцлог болох уулын гол ихтэй байдал, мөн халуун рашаан болон эрдэс бодисоор баялаг рашаан ус нь тухайн орчны хөрс, чулуулгийн өнгийг өөрчлөн улмаар түүгээр нэрлэсэн байдал илүүтэй илэрсэн болов уу. Түүнчлэн монголчууд үерлэсэн гол усыг *улаанаар эргэлдэх*, цус их асгарсан байдэл зэргийг *улаан нэлий* гэхчилэн цээрлэн үздэг нь гол усаа улаанаар цөөн нэрлэдгийн тайлал байж болох юм.

Эцэст нь хүмүний аливаа зүйлийг танин мэдэх үйл нийтлэг гэж үзвэл өнгөөр нэрлэж буй нь хүн төрөлхтөний нийтлэг болох нь гарцаагүй агаад нүүдэлчин ард түмэн газарзүйн биетийг өнгөөр нэрлэх нь мал сүргээ зүслэж, ялгаж ирсэн тэдний амьдралын туршлага газар нутгийн нэрд ч туссан гэдгийг харуулах хэлний баримт болох юм.



### НОМЗҮЙ

1. Н.И.Гармаева *Структурно-семантическая характеристика монгольских оронимов с цветовым компонентом*. Вестник Бурятского Государственного Университета, 2011: 85-88.
2. С.Дулам *Монгол бэлгэдэл зүй 2 өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй* УБ., 2007.
3. Д.Майдар *Гэр орон сууцны түүхэн тойм* УБ., 1976.
4. О.Т.Молчанова *Семантическое поле "красный цвет" в алтайском ономастиконе* Функционирование и историческое развитие диалектной и топонимической лексики, Барнаул, 1989:25-26.
5. О.Т.Молчанова *Алтайское кызыл, монгольское ulagan/ ulan в составе географических имен*. Всесоюзная научно-практическая конференция Исторические названия- памятники культуры сборник материалов. 1991. Выпуск 2:115-116.
6. *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь* эмхэт. ШУА-ийн ХЗХ. УБ., 2008.
7. Ц.Норжин *Монгол хэлний толь* Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999.
8. Э.Равдан *Орчин цагийн хэл шинжлэлийн үүд* УБ., 2005.
9. Э.Равдан, Т.Түмэндэмбэрэл *Монгол газар нутгийн нэрийн мянган домгийн чуулган*. УБ., 2012.
10. Б.Ринчен *Из нашего культурного наследия* УБ., 1958.
11. 上野智子『地名語彙の開く世界』和泉書院 2004.
12. 梅棹忠夫『The 日本—日本が見える、日本が読める大事典』講談社1986.
13. 新村出編『広辞苑』岩波書店1955.
14. 谷川健一『日本の地名』岩波書店1997.
15. 武井邦彦『日本色彩辞典』笠間書院1978.
16. 山中襄太『地名語源辞典』校倉書房 1968.

### SUMMARY

It is clearly seen from many different research sources that the frequency of colour noun constituents in Mongolian geographical names is relatively high. This tends to be explained by the feature of the nomadic naming tradition.

In the present paper, we attempted to compare the place naming of Japanese and Mongolian nations on the example of the word 'red'. As we collected from the most available and the largest sources of the place names of the two languages, there are 8753 Mongolian place names and 211 Japanese place names included the word 'red'. In Mongolian, these names are 4 percent and in Japanese they are 0.8 percent of all place names.

When naming a thing, human being concentrates on one particular feature among its many characteristics. Therefore, naming a geographic creature by color means that they paid attention on just one feature that can be likened to a color. In other words, it is definite that the geographic location or body that is being named by the color 'red' should not all or wholly be red as blood, flag or fire.

As we compared the geographic bodies named by 'red' in the two languages, Mongolians usually named mountains and their parts by the word whereas Japanese dominantly named rivers and its parts by the word. It doesn't mean that Japanese water is red by color but it is probably caused by the fact that the nature-geographic formation of Japan which has many mountainous rivers and hot springs rich with minerals has changed the color of the soil and rock of the areas. Besides, Mongolians rarely named rivers by the color 'red', probably, because they taboo flood as 'ulaanaar ergeldeh' and bleeding as 'ulaan nelii'.

Finally, naming places by color is universal among nations as the cognitive acts of human beings are universal. However, there are differences in choosing the names of colors for geographic bodies because of their lifestyle, historic experience and every difference they have.